

Манмин Мэдээ

№ 60 2018 оны 5 сарын 27

Хүүхдэд зориулан бэлтгэсэн Иосефийн итгэлийн тухай сургамжит аялал

Өсвөрийн библи судлалд зориулсан сурах бичиг “Бурханы амлалтын суваг болсон Иосеф” хэвлэгдэн гарлаа



Хүүхдийн цуглаанд бага болон өсвөрийн наснаас нь хүүхдүүдэд жинхэнэ итгэлийн амьдралын чиглэлтэй болгоно гэдэг нь үнэхээр чухал үйл явдал юм. 2018 оны 4-р сарын 17нд бага сургуулийн сурагчдад зориулсан И Жей руг пасторын долоо дахь цуврал ном “Бурханы амлалтын суваг болсон Иосеф” ном солонгос хэл дээр орчуулагдан гарлаа.

Энэ хүүхдийн сурах бичиг нь 17 настайдаа харийн улс болох Египет рүү боол болон зарагдан, амьдралийн ямар ч хүсэл тэмүүлэл, найдваргүй байдал дотроос Египетийн ерөнхий сайд болтол өргөмжлөгдөн, үүний улмаас Израйль гэх том улс үндэстэн бий болох үндсийг тавих хүртэлх Египетийн ерөнхий сайд Иосефийн итгэлийн тухай өсвөр насны хүүхдүүдэд зориулан сонирхолтой хэлбэрээр бүтээсэн юм.

Нийт 16 н бүлгээс бүрэлдэх ба энэ сурах бичиг нь бүлэг тус бүрээс суралцах гол зүйлийн тухай өгүүлэхээс өмнө тэдний сонирхолыг татсан, сургамжит жишээнүүд болон үлгэр ба өнгө алагласан зургаар эхлэн, тухайн бүлгээс сурсан зүйлээ эргэн давтах, өөрийн амьдралдаа хэрэгжүүлэх давтлагын булангаар төгсдөг байна.

Мөн Израйлийн өвөг дээдэс Иаков ба Бурханы зорилгыг биелүүлсэн Иосеф, Египетийн ерөнхий сайд Иосефийн амьдрал, Эхлэл номонд гардаг Иосефийн зарагдсан тухай үйл явц зэрэг төрөл бүрийн сургалтийн материал хамтдаа агуулагдан түүхийн тухай мөн мэдлэг өгөхөд чиглэгдсэн байдгаараа онцлог юм. Хэцүү бэрхшээл зовиур дунд ч зөвхөн Бурхан сайхан хүсэлд итгэж байсан Иосеф, маш

чадварлаг манлайлал дотор байгаа газар болгондоо хүлээн зөвшөөрөгдөн амжилтаар дүүрэн байсан Иосефийн сургамжаар өсвөрийн хүүхдүүдийн сэтгэлд хүний бодол төлөвлөгөөнөөс илүү агуу өндөрт орших Бурханы төлөвлөгөөг болон үргэлж сайныг өгөхийг хүсдэг Бурханы хайрыг гүн суулгахад маш дөхөм болгодог учир юм.

Хүүхдийн сурах бичиг нь <Өсвөрийн библи судлал>, “Сайны давхарга”, “Хичээл сайн хийх арга”, “Тэнгэрийн үүдийг нээх хүчит залбирал”, “Явцгаая! Үзэсгэлэнтэй тэнгэрийн орны аялал”, “Долоо дахь өдрийн тухай”, “Бурханы анд нөхөр Абрахам”, <Хүүхдийн библи судлал>, “Суралцангаа тоглоё”, “Би Есүсийг дуурайсан залбирлын жанжин” зэрэг нийт 18 төрлийн ном байдаг.

Хариулт ба ерөөлөөр дүүрэн байсан ‘2 удаагийн онцгой Даниел залбирлын цаг’ шагнал гардуулах ёслол

4-р сарын 8 ны өдөр орой 20 цаг 30 минут Төв сүмийн төв танхимд бэлтгэл магтан дуугаар эхлэн GCN Жи Си эн (www.gcntv.org) телевиз ба интернетээр дамжуулан 2 удаагийн онцгой Даниел залбирлын цагын шагнал гардуулах ёслол дэлхий даяар шууд дамжуулагдсан юм. Энэ удаагийн залбирал нь Манмин залбирлын хүрээлэнгийн ахлагч И Буг нимийн удирдлага дор 2-р сарын 26 наас эхлэн 42 хоногын турш “2018 оны 7-н залбирлын сэдэв” гэсэн сэдвээр орой 9 цагаас эхлэн Ариун Сүнсний бялхал дотор үргэлжлэн явагдсан юм.

Манмин залбирлын хүрээлэнгээс 40-с дээш хоног залбиралд оролцсон итгэгч нарын дундаас сугалаагаар 201 хүнд шагнал гардуулан, сугалааны дундуур Урлагийн багт харьяалагдах багуудийн ивээл дүүрэн тоглолтоор Бурхандаа талархал ба алдрыг өргөсөн юм. Тэргүүн шагнал нь И Жей руг тэргүүн пастор сугалсан бөгөөд энэ сугалаагаар Паг Ми суг туслагч (2-р Их тойрог 15-р бүлэг, зураг) тодорч, уг үйл ажиллагааны дараа ууланд залбиралд байгаа И Жей руг тэргүүн пастор утсаар бүх итгэгч нартаа хандан ерөөлийн залбирал хийж өгсөн юм.

Мөн Манмин залбирлын хүрээлэн жил бүр 2 удаа онцгой Даниел залбирлаас гадна 21 хоног

бүр тусгай сэдэв өгөн залбиран, GCN (Жи Си эн) телевиз ба интернетээр дамжуулан бүх дэлхийн хаана ч гэсэн Бурханы хаанчлал болон зөвт байдлын төлөө хичээнгүйлэн залбирсаар байна. Түүнчлэн өвчнөөсөө эдгэрэх, асуудлаасаа шийдүүлэхийг хүсч буй итгэгч нарынхаа төлөө ажлын өдөр өдрийн залбирал болон үдээс хойш залбирал үргэлжлэн явагдсаар байдаг.



Ертөнц ч дийлж чадахгүй ИТГЭМЖИТ НЭГЭН (1)

“Тэд хаанчлалуудыг эзэлж, зөвт байдлыг үйлдэн ... арслангуудын амыг хааж, галын хүчийг унтраан ... Зарим нь доромжлогдон, ташуурдуулсан ... хоосон тарчиг байн, зовж ад үзэгджээ. Тэдний хувьд дэлхий зохисгүй байжээ” (Еврей 11:33-38).



И Жей руг пастор

Итгэлийн бүлэг гэгдэх Еврей номын 11-р бүлэгт үзвэл Бурханыг баярлуулдаг итгэлийн өвөг дээдсүүд нь Бурханыг хайрласнаар үхлээс өчүүхэн ч айлгүй Бурханы төлөө бүх зүйлийг хаяж, ертөнц ч дийлэхээргүй итгэлийн хүчээр эр зоригтойгоор зөвт байдлыг хэрэгжүүлж байсан юм.

Энэ удаагийн дугаарт ертөнц дийлэхгүй итгэлээр тэд хэрхэн Бурханыг баярлуулж байсан хуучин гэрээний үеийн эш үзүүлэгчдийн тухай үзэжгээ.

1. Айдсыг хөөн зайлуулдаг төгс хайр

Анхны цуглааны итгэгчид туйлын хүнд хэцүү байдал, дарамт шахалтыг авмагцаа, өлсгөлөн арсланд бариулж, толгойгоо авахуулж байхдаа ч эцсээ хүртэл Есүс Христийг үгүйсгэлгүй, Бурханаас нүүр буруулагүй шалтгаан нь юу вэ?

1 Иохан 4:18д “Хайрын дотор айдас байдаггүй. Харин төгс хайр нь айдсыг хөөн зайлуулна. Учир нь айдаст ял байдаг. Айдаг нэгэн бол хайрын дотор төгс болгогдоогүй байна” гэж айлдсаны дагуу тэдэнд төгс хайр байсан учраас юм.

Хуучин гэрээнд гардаг Иов бол Бурханыг харахад цайлган, зөв шударга, зөвт нэгэн гэж хүлээн зөвшөөрөгдсөн ч түүний зүрх сэтгэлийн гүнд тавгүйтэл болон айдас байсан юм (Иов 3:25). Сорилтоор дамжуулан Бурханы хайрыг төгс ухаарсаны дараа эр зоригтой болж, өмнөхөөсөө хэд дахин ерөөлийг авсан юм.

Тэгвэл Бурханы хайрлан, айдас ба

тавгүйтэлгүй эр зоригтой үйлдэхийн тулд яах хэрэгтэй вэ? Бурхан библи дээр “Хий, Бүү хий, Хая, Сахь” гэж айлдсан тушаалуудыг үйлдэх нь Бурханыг үнэхээр хайрлаж байгаа хэрэг ба тэр хайр төгс болох тусам айдас тавгүйтлийг зайлуулж, эр зоригтойгоор зөвийг үйлдэх болдог (1 Иохан 5:3, 3:21-22).

2. Ертөнц дийлж чадаагүй хуучин гэрээний итгэлийн эш үзүүлэгчид

1) Галын хариултыг буулгасан Елиа

Хойд Израйлийн Елиа эш үзүүлэгч нь Баал болон Ашерийн шүтээнд үйлчилдэг 850 хуурамч эш үзүүлэгчидтэй сөрөн тэмцэн Бурханаас галын хариултыг буулган авсан юм (Хаадын дээд 18-р бүлэг). Хиймэл шүтээнд автагдсан ард түмний сэтгэлийг Бурхан руу эргүүлэхийн тулд чин сэтгэл ба бат итгэлтэйгээр Бурханы руу хандсан гал халуун хайрын хүчээр гав ганцаараа ч эр зоригтойгоор зөвийг үйлдсэн юм. Энэ мэт Бурхан ба Эзэнийг халуун хайрладаг итгэлээр боломжгүй зүйл гэж байхгүй юм.

2) Бодит байдлыг бэрхшээлд автаагүй Елиша

Елиагийн шавь болох Елиша эш үзүүлэгч нь маш тод онгод дотор Израйлийг цохих үйл ажиллагаа нь хэд хэдэн удаа бүтэлгүйтсэний дараа Израйлийн дайсагналцдаг Арам улс Елишаг хөнөөх оролдлого хийдэг юм. Олон удаагийн заналхийлэл, болон морьт болон тэрэгт их цэрэг илгээн түүний байгаа газрыг хүрээлэн бүсэлсэн байгааг харсан Елиша маш их айн сандарч байлаа.

Гэвч Елиша бидэнтэй хамт байгчид нь тэдэнтэй хамт байгчдаас хавьгүй олон юм гэсэн байдаг. Энэ үед Бурхан түүний сүнсний нүдийг нээхэд тэнгэрийн галт морьд болон тэргээр эргэн тойрны дахь уул нь дүүрсэн байгааг харсан юм. Эцэст нь Израйль агуу ялалт байгуулан Арамын цэрэг дахин Израйль руу зүглэж чадахгүй болсон юм (Хаадын дэд 6-р бүлэг).

Энэ мэт үнэхээр итгэлтэй бол бүхнийг чадагч Бурханд найдан түшдэг тул эргэн тойрны ямарч бэрхшээл саадаас огт айдаггүй. Бурханаас юуг ч гуйсан хариулж өгнө

гэсэн итгэлтэй тул эр зоригтойгоор гуйж, ийм итгэлийн залбирлаар Бурханы агуу хүчийг буулган асуудлыг шийдэх боломжтой учраас юм.

3) Өөрийн ард түмнийг аварсан Естер

Естер номын 3-р бүлгийн сүүл хэсэгт үзвэл хааны хайрыг онцгойлон хүртсэн Хаман гэгч нь Иуда үндэстэнийг бүгдийг устгах хуйвалдаан зохиоход Мордехаи нь Иуда бүсгүй хааны хатан Естерт Ахашверош хаанд мэдүүлж өөрийн ард түмнийг аврахыг гуйдаг.

Үүнийг сонссон Естер хатан өөрийн ард түмний төлөө Зоног мацаг барин “Үхвэл ч үхье” гэсэн сэтгэлээр хааны өмнө очиход Бурханы ивээлээр эцэст нь Хаманы төлөвлөөгөө бүтэлгүйтэн, өөрийн ард түмнээ авраад ч зогсохгүй харин ч хааны хайр энэрлийг хүртсэн юм.

Үхэл амьдралын зааг дээр ч бүх л асуудлын шийдэгч Бурханд бүх талаар найдсан тул хэрхэн үүнийг баярлан хүлээн авч хариулж өгөхгүй байх билээ. Уур хилэнг ерөөл болгож, Бурханы алдар илрэн гаргахад агуу ихээр нөлөөлснийг харж болох юм.

4) Үхлийн өмнө ч буулт хийгээгүй Даниел

Вавилоны эзэнт гүрний Дариус хаан Бурханд итгэдэг Иудей залуу Даниелаар дамжуулан өөрийн бүх газар нутгаа захируулахаар болоход үүнд атаархсан хүмүүс хэн ч байсан хаан өөр ямар ч бурхан шүтээнээс гуйвал арслангийн нүхэнд хаяхаар зальт тогтоол гарган мөрдүүлэхээр болдог.

Гэсэн ч Даниел Бурхан руу хандсан хайр нь үнэнч бөгөөд төгс байсан тул үхэхээс ч айхгүй байлаа. Эцэст нь арслангийн нүхэнд хаягдсан ч Бурхан тэнгэр элчээр дамжуулан арслангуудын амыг хааснаар өчүүхэн шархдаж бэртэлгүй хамгаалагдсан юм (Даниел 6-р бүлэг). Үхлийн аюулын өмнө ч буулт хийлгүй Бурхан руу хандсан хайр ба зөвт байдлыг бат сахиснаар агуу алдрыг өргөсөн юм.

5) Хувиршгүй итгэлээ сахисан Даниелийн гурван найз Шадрах, Мешах, Абед-него

Даниел номын 3-р бүлэгт

Вавилоны эзэнт гүрний Небухаднезар хаан алтан шүтээн бүтээж, түүндээ мөргөөгүй хүнийг галт зууханд хаях болно гэж тунхагласан юм. Гэтэл “Хиймэл шүтээнд бүү үйлчил” хэмээх Бурханы тушаалыг зөрчих чадахгүй Шадрах, Мешах, Абед-него нар хааны өмнө аваачигдахад, хаан одоо ч гэсэн мөргөхөд оройтоогүй ба мөргөвөл амийг нь өршөөх боломж өгсөн ч тэд огт бууж өгөөгүй юм.

Үхлийн өмнө энэ мэт зоригтой байж чадах хүч нь Бурхан руу хандсан төгс хайр нь бүх айдсыг хөөн зайлуулдаг учраас юм. Эцэст нь тэднийг ердийн үеийнхээс долоо дахин их галласан зууханд хаясан ч үс нь ч огт хуйхлагдаж түлэгдэлгүй амьд байж, Бурхандаа алдрыг өргөн хаанд улам ихээр хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүс болсон юм.

6) Итгэлийн дайчин Гидеон ба балчир Давид, Иудагийн хаан Иехошафат

Шүүгчид номын 7-р бүлэгт үзвэл Израйль нь далай эргийн элс мэт үй олон Мидиан цэргийн улмаас байдал маш түгшүүртэй байлаа. Гэсэн ч шүүгч Гидеон Бурханы үгэнд дуулгавартай даган, Бурханы удирдамжын дагуу цэрэг дайчдынхаа тоог багасган маш зоригтойгоор үйлдэн агуу ялалт байгуулсан юм.

1 Самуел номын 17-р бүлэгт гардаг балчир хүү Давид нь Бурханд итгэн эр зоригтойгоор аварга хүн Голиатын эсрэг дүүгүүр чулуутай гарч ирэн түүн духанд чулуугаа зооход тэр дороо сөхрөн унаж, Иудагийн хаан Иехошафат нь мөн л эргэн тойрны улс нэгдэн Өмнөд Иуда руу дайрахаар ойртоход бүх ард түмний хамтаар мацаг барин, залбирч, Бурханы үгэнд найдан, ариухан хувцас өмссөн хоор дуучдыг цэргийнхээ урд гарган талархалын магтаалыг дууг дуулуулсан юм. Ийм итгэлийн үйлсийг баярлан таалсан Бурхан тэдэнд агуу ялалтыг өгсөн юм (Шастирын дэд 20-р бүлэг).

Хайрт итгэгч та бүхэн, Бурханыг хайрлахдаа ямарч айдас сүрдэм байдлыг үлдэн хөөдөг төгс хайраар эр зоригтойгоор үйлдэн, боломжгүй зүйл байхгүй итгэлийг төгс эзэмшихийг Эзэний нэрээр хүсэн ерөөе.


Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00



Хаяг: Баянгол дүүрэг 16-р хороо Орхоны 1-33А Чуулганы ахлагч П.Батзориг

Утас: 88107327, 91170773, 89737773

www.manmin.org
www.gcntv.org

Жинхэнэ итгэн найдах ба хайрын нууц

Ариун гурвал Бурхан бол бидний амь амьдралаа зориулан хайраа өргөхөд зохистой бөгөөд төгс итгэж найдах болох нандин Эрхэм билээ. Тийм ариун гурвал Бурханд бид ямар найдлага болон хайраар хандаж байгаа билээ? Бурхан, Эзэн, Ариун Сүнстэй хэрхэн жинхэнэ найдлага ба хайраар холбогдохын нууцын тухай үзэцгээе.

Бурхантай дайсагнадаг
“Махан биеийн бодол”
-г хаях ёстой.

Ром номын 8-р бүлгийн 7д “Яагаад гэвэл махан биеийн бодол санаа бол Бурханы эсрэг дайсагнал юм. Учир нь энэ нь Бурханы хууль захирагддаггүй бөгөөд тэгж чадахч үгүй” гэсэн байдаг. Тэгвэл Бурханы эсрэг дайсагнадаг махан биеийн бодол гэж юу вэ?

“Махан биеийн бодол” гэдэг нь хүний зүрх сэтгэлд буй элдэв хорон муу нь сэтгэн бодох үйл явцын нөлөөгөөр илрэн гарч, дур хүслийг өдөөн сэтгэл зүрхийг хөдөлгөн ганхуулж, Бурханы хүсэж буй сүнс талын итгэлтэй болоход том саад болдог.

Ойлгоход амархан жишээ татахад, ердийн үед хэвийн сайн харилцаатай хүн тань нэгэн өдөр гэнэт царай баргар, мэнд ус ч үгүй өнгөрөхөд “Би энэ хүнийг яасан юм бол? Гайгүй хүн гэж бодож байтал харин бүдүүлэг, дотуур хүн байхнээ” гэж хормын зуур урьдын бодлоо өөрчилдөг. Бусдын нөхцөл байдалд огт санаа тавилгүй өөрийн хувирамтгай, дүгнэх зан байдлаасаа болж бусдыг амархан буруутган шүүх тохиолдлыг хэлж болно.

1 Самуел номын 6-р бүлэгт Давид хаан Бурханы гэрээний авдар Иерусалим хотод орж ирж байгаад маш их баярлан бүжиг бүжиглэн Бурханын магтахад түүнийг харж байсан Михал хатан нь “Мунхаг хүмүүсийн нэг нь ичгүүргүйгээр нүцгэлдгийн адил” гэж өөрийн нөхрийг доромжлон эгдүүцэж байв. Бурханыг харахад цайлган Давидийн энэ үйлдлийг

Михал өөрийн атгаг болон бардам байдлаар дүгнэсэн хэрэг юм.

Лук номын 13-р бүлэгт Есүс нэгэн Амралтын өдөр синагогт 18н жилийн турш чөтгөрт эзэмдүүлж бөгтөр болсон эмэгтэй дээр мутраа тавихад тэр дороо эдгэрч, Бурханд алдрыг өргөсөн юм.

Гэтэл синагогийн захирагч Амралтын өдөр өвчин эдгээлээ гэж дургүйцэн уурлаж, цугларсан олонд Амралтын өдөр биш өөр өдөр ирж өвчнөө эдгээлгэ гэдэг. Бурханы эрх мэдэлт хүч гарч, маш хэцүү зовиур дотор байсан хүн Бурханы хайрыг авлаа гэх талаар огт бодож чадахгүй байсан юм. Түүний сэтгэлд хайр ба сайхан сэтгэл байхгүй тул өөрийн зөв хатуу үзэл баримтлалаар дүгнэн, Бурхан хүсэл гэж зөрүүдэлж байгаа хэрэг юм.

Үүн шиг зүрх сэтгэл дотроо үзэн ядалт, атаархал, шунал гэх мэт хорон муу болон өөрийн зөв гэх хатуу үзэл бодлоос болж махан биеийн бодол санаа гарч, сайны үйлсийг хорон муу гэж дүгнэдэг тул юуны түрүүнд Бурхантай дайсагнах махан биеийн бодол санаагаа бүгдийг нь хаях хэрэгтэй юм. Сайн зүйлийг сайн гэж ухааруулдаггүй өөрийн атгаг байдлыг илрүүлэн хурдан хаяснаар бүх зүйлд сүнсний бодлоор хандах хэрэгтэй. “...Сүнслэг зүйлсийг сүнслэгээр тайлбарладаг” (1 Коринт 2:13) үгийн дагуу сүнс болох Бурханы зүрх сэтгэлийг ухаарч Ариун гурвал Бурханд итгэн найдах хэрэгтэй юм.

Ариун Сүнсний дууг
сонсон хөтлөгдөн, сайны
хүслийг ухаарах хэрэгтэй.

Матай номын 15-р бүлэгт гарах харь эмэгтэй нь өөрийн охинд шүглэсэн чөтгөрийг зайлуулж өгөх гуйхад Есүс “Хүүхдүүдийн талхыг авч, нохдод өгөх нь сайн хэрэг биш ээ” гэж айлдсан байдаг. Тэгсэн ч энэ эмэгтэй огтхон ч гомдолгүй харин өөрийгөө даруу болгож, “Тиймээ Эзэн. Гэвч ноход ч эздийнхээ ширээнээс унасан үйрмэгээр хооллодог шүү дээ” гэж эцсээ хүртэл гуйн Эзэнээс зуурдаг юм.

Энэ мэт даруу сэтгэлийн үгийг сонссон Есүс тэр эмэгтэйн итгэлийг сайшаан магтаж, тэр даруй хариулж өгсөн байдаг. Хэрэв тэр эмэгтэй сэтгэл тавгүйтвэл Есүст гомдох болох байсан ба сэтгэлээр унаж хариулт авахаас ч татгалзах байсан юм. Гэсэн ч тэр эмэгтэйд хариулт авах итгэл байсан учир сайхан сэтгэлийн үгээр эцсээ хүртэл Эзэнээс зуурсан юм.

Есүс энэ эмэгтэйн итгэлийг хэдийн мэдэж байсан тул эцсээ хүртэл итгэлээ үзүүлтэл нөлөөлж, хариулт авах хэмжээний шударга ёсонд нийцтэй үйлсийг дүүргүүлэхийн тулд байлаа. Мөн Бурханд итгэдэг гэсэн мөртлөө хариулт авч чадахгүй үедээ

амархан сэтгэлээр унах, юмуу Бурханд гоморхон хувирамтгай хүмүүст жинхэнэ итгэл гэж юу болох талаар үзүүлэхийн тулд энэ эмэгтэй үгийг иш татсан юм.

Сайхан сэтгэлтэй хүн Есүсийн сайн ба хайранд итгэдэг тул Есүс яагаад тэгсэн тухай бодож тунгааадаг юм. Эзэнийг хүлээн авч Ариун Сүнс авсан хүн зүрх сэтгэл дэх атгаг байдлыг хаяж, махан биеийн бодол санааг хаях тусам Ариун сүнсээр хөтлүүлж, сайнаар ялган зааглаж чаддаг. Ариун Сүнсний хүч нөлөөн дунд Бурханы сайхан хүслийг ухаарах боломжтой учраас юм.

Гэхдээ миний дотор хорон муу бодол болон үнэний бус мэдлэг, ертөнцийг хайрлах сэтгэл байсаар байвал туслагч Ариун Сүнснээс нөлөөлөх боломжгүй юм. Махан биеийн бодлыг хагалж байж Ариун сүнсний тусламжыг авч сайхан сэтгэлээр бодож тунгаах тусам илүү гүн гүнзгий хүслийг ч ухаарах боломжтой ба ингэж ухаарах тусам итгэл найдвар ч аажим аажмаар гүнзгийрдэг юм.

Хайр ихсэх тусам итгэн
найдах ч ихсдэг.

Эзэний хайртай шавь Петр нь Есүсийн үйлчлэлийн үед үргэлж хамт байж, Есүст итгэн найдаж, хайрладаг байсан ч Түүний загалмайд дахь үйл явдлын дараа тэр хайрын хэмжээ улам гүнзгийрсэн байдаг. Өөрийнх хамгаас илүү хайрладаг багш, сайн ба хүндэтгэл авах зохистой Бурханы Хүү өөрийнх нь нүдний өмнө маш аймшигтайгаар зовлонг эдэлсэн юм. Гэтэл тэр Түүнийг хамгаалах нь байтугай мэдэхгүй, танихгүй гэж үгүйсгэн, бүр хараал урсган тэр үед холдон явсан юм.

Гэсэн ч Есүс түүнийг огт зэмлэлгүй зүгээр л түүн рүү ширтэн харж, тэр хүнд бөгөөд аймшигтай загалмайг үүрэн цовдлогдсон юм. Өөрийнх нь төлөө амиа зориулсан Есүсийн зовлонг харсан Петрийн Эзэн

рүү хандсан хайр нь өмнөхөөсөө өөр болж, тэр хайр гүнзгийрэх тусам итгэн найдах сэтгэл ч огт өөр болсон юм.

Өмнө нь ийм зүйлд айж сүрдэж байсан ч одоо өөрөөс нь байр сууриар өндөр хүмүүсийн дунд сайн мэдээг маш зоригтойгоор тунхаглах төдийгүй загалмайд хүртэл доошоо харан цовдлогдон амиа зориулахдаа Бурханд хандан найдах сэтгэл нь ч огт ганхаагүй юм Зөвхөн гал мэт халуун хайраар бат итгэл найдвараар алдартай амиа зориулж чадсан юм.

Энэ мэт жинхэнэ найдлага ба хайраар төгс нэгдэн энэ газар дээр ч төдийгүй хамгийн үзэсгэлэнтэй тэнгэрийн орон Шинэ Иерусалимд Ариун гурвал Бурхандаа талархал ба хайрыг өргөхийг хүсье.

1998 оны 2-р сард би тухайн үед Африкт амьдардаг эгч дээрээ очихоор Кения руу явсан юм. Эгчийнхээ ажилдаг үсчний газарт очиход тэнд байнга ирэх Найроби Манмин сүмийн сайн мэдээ тунхаглагч ахлагч нартай уулзаж, “Манмин”-ы тухай И Жей руг тэргүүн пасторын тухай аяндаа мэддэг болсон юм. Манмин төв сүмийн урлагын багийн тоглолтын бичлэгийг ч хүртэл үзэхэд маш гайхалтай чадварлаг, байсан “Ийм сүм байхнээ. Дараа заавал очиж үзнээ” гэж бодож байлаа.

10н сарын дараа би Солонгос руу буцан ирээд Манминий итгэгч болсон юм. Тэр үеэс л эхлэн төрөл бүрийн мөргөл ба Даниел залбирлын цагт оролцон аз жаргалтай итгэлийн амьдралаар амьдарч урлагын багт орж үйлчлэх хүртэл ерөөл авсан юм.

Үнэндээ бага наснаас бүжигт

сонирхолтой байсан ба их ам байхдаа ч урлагын тэмцээн наадамд оролцож байсан бөгөөд бүхнийг мэдэгч Бурханы энэ мэт удирдамжинд байгаадаа маш талархаж байлаа. 2003 оноос эхлэн тэргүүн пасторын гадаад дах нэгдсэн их цуглааны тоглолтын багт орж, И Жей руг тэргүүн пасторын залбирлаар дамжуулан гарах Ариун сүнсний хүчит үйлсийг харан итгэлээр өсч байлаа.

2009 оноос эхлэн урлагын багийн тоглолт дахь бүжиг дэглэлт, багийн шинэ гишүүдийн сургалтад хичээнгүйлэн оролцож байна. Зүрх сэтгэлээ шинэчилж, өөрчлөхийн тулд хэн ч биш намайг Кениягаас Солонгос руу Манминий итгэгч болгож, Эзэний ажилтан болгож өгсөн Бурхандаа бүх хүчээ зориулж байлаа.

2015 оны 6-р сард би Бурханы үгийн дагуу гэмийг цус урсгах

“Хязгааргүй хайр ба эрх мэдэлт хүчээр удирдаж өгсөн Ариун гурвал Бурхан минь талархаж байна”

У Ми геон сүмд үйлчлэгч (40 нас, 2-р Канаан бүлэг)




хүртэл тэмцэн хаяж, бүх л хорон муугийн бүх хэлбэрийг хаяхын төлөө хичээсэн байх төлөө сүнсний сэтгэлтэй болсон юм. Хичнээн баяр хөөр аз жаргалтай байсан гээч. Тэгтэл нэгэн өдөр ханиалгаж эхэлсэн ба тасралтгүй ханиаж байсан тул эмнэлэгт үзүүлэлт уушгины сүрьеэтэй болсоноо олж мэдсэн юм. Тэр үед яг л цэлмэг өдөр аянга буух мэт маш цохилтонд орохоор мэдээ байсан ч айж эмээхээс илүү хайрын уг үндэс болох Бурхан Аавын сайхан хүслийг бодон залбирал хийсэн юм. Хамгийн үзэсгэлэнтэй тэнгэрийн орон Шинэ Иерусалимд оруулахын

төлөөх сорилт болон Бурханы агуу хүслийг ухаарсан юм.


Би Египетээс гарсан нь номын 15:26д бичигдсэн байдаг “Эдгээгч Эзэн”д итгэдэг тул итгэлээрээ эдгэрэхийн тулд илүү ихээр залбиралд өөрийгөө зориулсан юм. Тэгтэл зүүдэнд тэргүүн пастор үзэгдэх юмуу залбирал авсанаар эцэст нь эдгэрлийн нөлөө мэдрэгдэж эхэлсэн юм. Хайрын Бурханаас би өмнө гэмшсэн ч төгс гэмшиж чадаагүй зүйлийг хүртэл эргэн сануулж өгч, чин сэтгэлийн гэмшилд хүртэл нөлөөлж өгөн, цэвэрхэн эдгээж өгсөн юм. Халлелүяа!

2018 онд би багийнхаа бүжиг дэглээчийн хувьд илүү сайн бүтээл гаргахын тулд хичээнгүйлэн суралцаж, дэлхийн хязгаар хүртэл сайн мэдээг тараадаг GCN(Жи Си эн) телевизийн вошип бүжгийн нэвтрүүлгийн хариуцагчын хувьд маш завгүй өлрүүдийг өнгөрөөж байгаа билээ. Бүх дэлхийн үй олон хүмүүст тэнгэрийн орны тэмүүлэл ба тэргүүн пасторын агуу эрх мэдэлт хүчийг илүү дамжуулахыг хүсэн бүхэн талархал ба алдрыг хайрын Ариун гурвал Бурхандаа алдрыг өргөө.

Цээжний рентген зураг



▲ Залбирал авахын өмнө: Баруун талын уушиг сүрьеэгийн улмаас гүн үрэвссэн байдал



▲ Залбирлын дараа: Уушгины сүрьеэгээс үүдэлтэй үрэвсэл бүрэн эдгэрсэн байдал

“Манмин бол онцгой бөгөөд бусдаас өөр!”

Олег Диаченко пастор (47нас, ОХУ, Санкт-Петербург хот, Өглөөний од чуулган)



ОХУ-н Манмин салбар чуулганы ерөнхий удирдагч Владимир Осифоф пастор нь “Манмин”-тай хамтран сайн мэдээний үйлчлэл хийнгээ Эзэн дотор өөрчлөгдөн, арвин дүүрэн үр жимс боловсорч байгааг нүдээр харлаа гэсэн юм. Тиймд би ч гэсэн “Манмин”-тай хамтрахыг хүсч, 2008 онд Манмин төв сүмд анх удаа зочлон, И Жей руг тэргүүн пастор болон пастор номлогч

нартай уулзан маш их ивээл авч байсан минь одоо тодхон санагдаж байна.

Энэ жил ч гэсэн баяр хөөртэй сэтгэлээр бусад пасторуудтай хамт дахин зочлон очсон юм. Бид Манмин төв сүмд хамтдаа мөргөлд оролцож, залбирал хийнгээ гал халуун уур амьсгал дотор, Ариун сүнсний бялхалаар дүүрсэн юм.

Энэ нь бидэнд маш чухал үйл явдал болсон юм. Тэргүүн

пастортай уулзах уулзалт ч маш гайхалтай байлаа. Тэрээр үргэлж Бурхан Аавын сэтгэлээр бидэнтэй ярилцаж хүндэтгэлтэй болон даруу дөлгөөхөн байдлыг харлаа. Манминий итгэгч нар ч маш онцгой бөгөөд тэднийг харах болгонд харьцах болгон бидэнд маш ивээл өгч байлаа.

Дахин амилалтын баярын тоглолт маш чадварлаг үгээр илэрхийлэхийн аргаггүй юм. Тоглолт нь мэргэжлийн түвшинд

байсан урьд нь миний үзэж байсан тоглолтуудаас хамгийн шилдэг нь байсан юм (Баруун талын зураг). Загалмай дээрх Эзэний дүр төрхийг харахдаа би нулимс унагахгүй байж чадаагүй юм. Түүнчлэн тухайн тоглолтын хөгжим, болон музикл загалмайд цовдолж байгаа дүрслэл нь яг л бодит мэт байсан нь үнэхээр гайхалтай байсан юм.

Мөн Есүсээс урвасан Искарриотын

Иудасийн ийм харамсалтай дүр төрхийг ингэж нарийн чадварлаг дүрсэлж байгааг анх удаа л харж байсан юм. Эзэн дахин амилахад үлэмж баяр хөөрөөр дүүрэн авсан ба би Манминаас ивээл ба тэр сэтгэл хөдлөлийг нутагтаа буцаж очоод тараан түгээхийг хүсч байна. Халлелүяа!



УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminninen@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин